



Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2018

АГУУЛГА

Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс	3
Стратегийн зорилтууд	4
Мэндчилгээ	5
2018 оны онцлох үйл явдал	7
Гишүүнчлэл	8
Бодлогын өмгөөлөл	9
Хамтын ажиллагаа	10
Судалгаа	12
Арга хэмжээ	13
Шагнал, шалгаруулалт	15
Бизнес уулзалтууд	16
Үзэсгэлэн	17
Сургалт	19
Танхимын үйлчилгээ	20
Төсөл хөтөлбөр	21
Танхимын дотоодод хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	24
Хавсралт	26

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

- Стратегийн зорилт 1:** Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх
- Стратегийн зорилт 2:** Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах
- Стратегийн зорилт 3:** Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах
- Стратегийн зорилт 4:** Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх
- Стратегийн зорилт 5:** Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах
- Стратегийн зорилго 6:** Танхимын засаглал, менежментийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх

МЭНДЧИЛГЭЭ

МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАЖАВ



МҮХАҮТ-ын Удирдах зөвлөл, Тэргүүлэгч гишүүд, нийт гишүүн байгууллага, бизнес эрхлэгч Та бүхэндээ юуны өмнө 17-р жарны “Урвуулагч” хэмээх шороон гахай жилийн сар шинийн мэндийг дэвшүүлье. 2018 онд улсын хэмжээнд нийт 85 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулан, 800 гаруй мянган иргэдийг ажлын байраар хангаж, нийт 8.2 их наяд төгрөгийг Улсын төсөвт бүрдүүлж, төлөвлөснөөс 29 хувь, ААНОАТ-ыг өмнөх оныхоос 32 хувиар давж төвлөрүүлэн, өөрсдийн үүргийг хариуцлагатайгаар биелүүлэн ажиллалаа.

МҮХАҮТ-аас 2018 оныг “Бизнесийн тогтвортой орчныг дэмжих жил” болгон зарлаж, бизнест шууд болон шууд бусаар нөлөө үзүүлэх хууль, бодлогын баримт бичиг дээр ажиллан, нийт 90 гаруй Төрийн байгууллагын хороо, зөвлөл, ажлын хэсэгт бизнес эрхлэгчдийн дуу хоолой болж ажиллалаа. Тухайлбал, Татварын багц хууль, Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудад онцгой анхаарал өгч, УИХ-ын Байнгын хороо болон Засгийн газарт байгуулагдсан ажлын хэсэгт бизнесийн эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан, УИХ-аар хэлэлцэгдэх хүртэл бүхий л шатанд идэвхтэй ажиллалаа.

Түүнчлэн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын 22 байгууллагатай санамж бичиг байгуулсан бөгөөд, анх удаа Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан нь Төр-Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах үйл явдал болсон юм. Мөн бизнес эрхлэгчдийн дуу хоолойг бодлого боловсруулагчдад шууд хүргэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх “Бизнес уулзалт”-ыг Монгол Улсын Ерөнхий Сайд, Салбарын сайдуудыг оролцуулан зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн тавьсан тодорхой асуудлыг шийдвэрлүүлсэн зэрэг үр дүнтэй олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

МҮХАҮТ-ын Удирдах зөвлөл, Тэргүүлэгч гишүүд, нийт гишүүд Та бүхэндээ бидний үйл ажиллагааг дэмжин ажилласанд талархал илэрхийлж, цаашдын ажил үйлсэд нь амжилт хүсье.

**МҮХАҮТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙЛӨГЧ**

Б.ЛХАГВАЖАВ

МЭНДЧИЛГЭЭ



МҮХАҮТ–ЫН ДАРГА М.ОЮУНЧИМЭГ

МҮХАҮТ–ын хамт олон, хамтран ажиллагч байгууллага, бизнес эрхлэгч Та бүхний дэмжлэгтэйгээр 2018 онд үр дүнтэй олон ажлуудыг хийж гүйцэтгэн, амжилт бүтээлээр дүүрэн байлаа.

МҮХАҮТ–ын зүгээс үйл ажиллагаагаа олон улсын түвшинд хүргэх, харилцагч, гишүүддээ стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх зорилгоор хоёр томоохон төслийг амжилттай хэрэгжүүллээ. Танхимын хамт олон 2016–2018 онуудад чанарын удирдлагын ISO 9001:2015 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дэлхийд нэр хүндтэй Швейцарийн “SGS” компаниас баталгаажуулалтын гэрчилгээг оны өмнөхөн гардан авлаа. Мөн Олон Улсын Худалдааны Төвийн “Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг” төсөлд хамрагдаж, үр дүнд нь дэлхийн бусад танхимуудтай харьцуулсан өөрсдийн үнэлгээг 2016 оны үзүүлэлтээс 25 хувиар сайжруулж, бүх үзүүлэлтийг дундажаас дээгүүр болгон, сул талгүй болж чадсан юм.

Мөн Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ–ын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгчийн Монгол Улс дахь айлчлал болон бүс нутгийн бизнес уулзалтыг 2018 оны 9–р сарын 5–10–ны хооронд амжилттай зохион байгууллаа. 2018 онд олон удаагийн гадаад, дотоод бизнес уулзалт, үзэсгэлэнг зохион байгуулсан бөгөөд үүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлага “Монгол–Оросын санаачилга–2018” чуулга, үзэсгэлэн, Монгол Улсын Ерөнхий Сайдын БНХАУ, БНСУ, Япон улс дахь гадаад айлчлалын хүрээнд бизнес уулзалтуудыг амжилттай зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн талархлыг хүлээсэн билээ. Түүнчлэн бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал, тэдний санал, зөвлөмжийг үндэслэлтэй Төр, Засагт хүргүүлэх зорилгоор Бизнес итгэлийн индекс, Хүнд суртлын индекс судалгааг шинэ аргачлалаар явуулж, үр дүнг Төрийн эрх баригчдад хүргүүлэн ажиллав.

МҮХАҮТ, Германы Танхимын хамтран хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй “Хонины ноос болон чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл”–ийг “Олон Улсын Худалдааны Төв”–өөс өндрөөр үнэлэн, НҮБ–ын “Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж буй байгууллага”–аар онцолж, шагнал олголоо. Түүнчлэн Танхим, Дэлхийн Банкны “Экспортыг дэмжих төсөл”, Европын Холбооны “Худалдааг дэмжих төсөл”–ийн хүрээнд экспортыг дэмжих, экспортлогчдыг чадавхжуулах, сургалт, арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсан. Мөн дэлхийд алдартай “McKensley & Company” байгууллагатай хамтран “Байгууллагын хөгжлийн индекс”–ийн үнэлгээнд аж ахуйн нэгжүүдийг хамруулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Танхимын нийт гишүүн байгууллага, харилцагчид, түншүүд, бизнес эрхлэгч Та бүхэнд 2018 онд бидний үйл ажиллагааг дэмжин, хамтран ажилласанд нь талархал илэрхийлж амжилт хүсэхийн ялдамд өнгөрсөн оныг амжилт бүтээлээр дүүрэн үдсэн танхимын хамт олондоо ирж буй жилдээ илүү санаачилгатай, бүтээлч, өрнүүн ажиллахыг хүсье.

МҮХАҮТ–ЫН ДАРГА


М.ОЮУНЧИМЭГ

2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ–уудын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Джамал Инайшвили Монгол улсад айлчиллаа.
- Танхимын дарга Ази Номхон Далайн Орнуудын Худалдаа Аж үйлдвэрийн Танхимуудын Нэгдсэн Холбооны дэд ерөнхийлөгчөөр улиран сонгогдсон.
- “Олон Улсын Худалдааны Төв”–өөс МҮХАҮТ, ГХАҮТХ хамтран хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй “Хонины ноос болон чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл”–ийг НҮБ–ын “Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд их хувь нэмэр оруулж буй байгууллага”–аар онцолж үнэлэн шагнал олголоо.
- Бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай хамтран ажиллах санамж бичиг зурсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ–ын Ерөнхийлөгч В.В.Путин нарын санаачлагаар “Монгол–Оросын санаачилга–2018” цуврал арга хэмжээний хүрээнд бизнес форумыг 6 дугаар сарын 7, 8 –ны өдрүүдэд зохион байгуулж ОХУ–аас 200 орчим төлөөлөгч, Монголын 400 гаруй компанийн төлөөлөгч нар оролцсон.
- МУ–ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ–д айлчлал хийсэнтэй холбогдуулан “Монгол–Хятадын бизнес форум”–ыг нийт 300 бизнес эрхлэгчийг хамруулан амжилттай зохион байгууллаа.
- МҮХАҮТ үйл ажиллагаандаа ISO 9001 олон улсын чанарын удирдлагын тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Швейцарийн Женевт төвтэй “SGS” компаниас баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан.
- ИТС–Олон улсын худалдааны төвөөс “МҮХАҮТ–ын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг” төслийг хэрэгжүүлсний үр дүнд 2018 онд тус байгууллагаас танхимд хийсэн харьцуулсан үнэлгээгээр 57.84% гэсэн үр дүнтэй гарсан нь 2016 оны үнэлгээтэй харьцуулахад 25 гаруй хувиар өссөн нь богино хугацаанд гарсан том амжилт гэж үнэлэгдсэн.
- Монгол улсад төр хувийн хэвшлийн хэлэлцлийн механизмыг хөгжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэд Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хороо байгуулагдсан нь бизнес эрхлэгчид төр засагт дуу хоолойгоо хүргэх, салбарын тулгамдсан асуудлаа төрийн байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх боломжийг бүрдүүлсэн. МҮХАҮТ–ын дарга М.Оюунчимэг хувийн хэвшлийг төлөөлөн тус хорооны дэд даргаар ажиллаж байна.
- Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын хүсэлтээр МҮХАҮТ–ын баруун бүсийн 5 салбар танхим Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсын баруун бүс нутагт нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагааг дэмжих нь” төслийн судалгааны ажилд амжилттай оролцсон.

ГИШҮҮНЧЛЭЛ

2018 онд МҮХАҮТ–ын нийт гишүүдийн тоо 3395 болж өссөн. Үүнээс орон нутгийн гишүүн байгууллагуудын тоо 2115, Улаанбаатар хотын гишүүдийн тоо 1280 болж өмнөх оноос 150–аар нэмэгдэв.



Танхимын гишүүдэд мэдээлэл хүргэсэн байдал:

269 удаагийн давтамжтайгаар нийт 1290497 цахим шуудан илгээснээс үзэлтийн тоо нь 311662 байна.

Шинэ гишүүдийн үйл ажиллагаатай танилцсан байдал:

Танхимд гишүүн байгууллагаар элсээд нэг жил болсон 46 аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай танилцах аянаар танхимын удирдлага, газрын дарга нар мэргэжилтнүүдийн хамтаар зочлон танхимын бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай болон бизнест тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцон, саналуудыг холбогдох газруудад хүргэн ажилласан.



Оны онцлох аж ахуй нэгжийн аялал:

2017 оны ООААН–ээр шалгарсан 11 компанийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аянг зохион байгуулсан бөгөөд нийт 313 бизнес эрхлэгчийг хамруулсан. Үүнд:

1. Хаан банк
2. Эрдэнэт үйлдвэр
3. Голомт банк
4. Ай Ти Зон
5. АПУ ХК
6. Мобиком корпораци
7. Тэсо групп
8. М–Си–Эс Кока кола
9. Гоёл кашмер
10. Сүү
11. Номин Холдинг



БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

МҮХАҮТ–аас 2018 оныг бизнесийн тогтвортой орчныг дэмжих жил болгон зарласан бөгөөд энэ хүрээнд бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, бизнесийн эрхлэх хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллав.

Бодлогын баримт бичиг, хуулийн болон журмын төслүүдийг боловсруулах чиглэлээр нийт 9 хуулийн төсөл, 7 бодлогын баримт бичиг, журамд санал өгсөн ба давхардсан тоогоор 11 хэлэлцүүлэг зохион байгуулж, 3 мэдэгдэл гаргасан.

Бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай хамтран ажиллах санамж бичгийг 2018 онд зурж хамтын ажиллагааг эхлүүлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, МҮХАҮТ хоорондын байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”–ийн хүрээнд Улсын Их Хурлын Даргын орон тооны бус зөвлөхөөр МҮХАҮТ–ын Тэргүүлэгч гишүүн, Барс группын Ерөнхийлөгч Ч.Амарбаатарын нэрийг дэвшүүлж, томилуулсан ба УИХ–ын НББСШУ–ны Байнгын хорооны Хөдөлмөрийн хуулийг өргөн барих дэд ажлын хэсэг, УИХ–ын Эдийн Засгийн Байнгын хорооны Хөрөнгө оруулалтын банк, Татварын багц

хуулийн дэд ажлын хэсэгт Танхимын удирдлага болон Тэргүүлэгч гишүүдийг хамруулан, ажиллав.

МҮХАҮТ–ын Эдийн засгийн бодлогын зөвлөлөөс “Монгол Улсын сүүлийн гурван жилийн Улсын төсөвт хийсэн судалгаа, цаашид сайжруулах санал”–ыг боловсруулж УИХ–ын дарга, Төсвийн байнгын хорооны дарга, Төсвийн Зарлагын дэд хорооны даргад тус тус хүргүүлсэн.

Бизнес эрхлэгчид салбарын болон тодорхой асуудлаар санаа бодлоо солилцох, бодлогын өмгөөллийн чиглэлээр нэгдэх, салбарын төрийн байгууллагуудтай хамтран ажиллах зорилго бүхий 20 бизнесийн зөвлөл (Хавсралт 1) Танхимын дэргэд ажиллаж байна. Танхимаас гаргаж байгаа хууль эрх зүйн баримт бичгийг эрх зүйн хувьд зөв, үндэслэлтэй гаргах хэрэгцээ шаардлагыг харгалзан 2018 оны 12 сард Хуулийн бодлогын зөвлөлийг нэмж байгуулсан.

Мөн бизнес эрхлэгчдээс ирүүлсэн тодорхой санал, гомдол, хүсэлтүүдийг нэгтгэн Монгол улсын Засгийн газар болон холбогдох яам агентлагуудад уламжилсан. Үүнд:

1. МУ–ын Ерөнхийлөгчид бизнесийн орчинд тулгарч буй хүндрэл, яаралтай авч хэрэгжүүлэх зарчмын болон бизнес эрхлэгчдээс ирүүлсэн Төсөв, татвар, холбогдох бусад санал
2. МУ–ын Ерөнхий сайдад Бизнесийн орчин, татварын орчин, ТХХТ–ийн талаар санал
3. Сангийн сайдад данс хаалгасан ААН–үүдийн талаар санал
4. Мянганы сорилтын корпорациас хэрэгжүүлэх ажилд санал
5. Монгол–Оросын Засгийн газар хоорондын комисст чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах талаар санал
6. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол–Хятадын Засгийн Газар Хооронд Комисст экспортыг нэмэгдүүлэх, 2 улсын дамжин өнгөрөх тээврийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах чиглэлээр санал хүргүүлсэн.

2018 онд МҮХАҮТ–ын төлөөлөл нийт 96 хороо, зөвлөл, комисс, ажлын хэсэгт (Хавсралт 2) гишүүнээр орж ажилласан. Үүнээс 48 хороо, удирдах болон ерөнхий зөвлөл, 48 ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Санал өгсөн хуулийн төсөл

1. ЖДҮ–ийн тухай хууль
2. Татварын багц хууль
3. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
4. Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль
5. Уул уурхайн багц хууль
6. Худалдааны хуулийн үзэл баримтлал
7. Оюуны өмчийн багц хууль
8. Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
9. Монгол улсын 2019 оны төсвийн тухай хууль

Бодлогын баримт бичиг, журам

1. Нийслэлийн Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах журмын төсөл
2. Худалдаа, хөрөнгө оруулалтын газрын зураг болон экспортын замын зургийн төлөвлөгөө
3. “Барилгын салбарт төрөөс баримтлах бодлого”–ын төсөл
4. ХАА–н биржийн хураамжийн талаар Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хороонд санал өгсөн.
5. Байгал орчны багц 30 хуулийн давхардал
6. Нийслэлийн ИТХ–ын 70–р тогтоол
7. “Монгол экспорт” хөтөлбөр

Мэдэгдэл, уриалга

1. Төрийн хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, Нийтийн санхүүгийн ил тод байдлыг хангах тухай
2. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх 7 хоногийн аян
3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын Чуулганаар дахин хэлэлцэх тухай

Хэлэлцүүлэг уулзалт

1. Худалдаа хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн хэлэлцүүлэг
2. Татварын багц хуулийн 3 удаагийн хэлэлцүүлэг
3. ЖДҮ-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх 3 удаагийн хэлэлцүүлэг
4. Төрийн худалдан авалт-Дотоодын үйлдвэрлэл хэлэлцүүлэг
5. Экспортод тулгамдаж буй асуудлууд сэдэвт хэлэлцүүлэг
6. Хөдөлмөрийн хуулийн 2 удаагийн хэлэлцүүлэг

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн ба төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, аймаг дүүргүүдийн засаг захиргааны нэгжүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төрөл бүрийн арга хэмжээ хамтран зохион байгуулах үйл ажиллагаа явуулах зорилгоор дотоодод нийт 7, гадаадын худалдааг дэмжих 15 байгууллагатай тус тус санамж бичигт гарын үсэг зурж хамтран ажилласан.

Дотоод хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ

1. Багануур дүүрэг
2. Скай Хайпермаркет ХХК
3. Монголын хуульчдын холбоо
4. Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
5. Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль
6. Засгийн газрын хэрэг эрхлэх газар
7. Сайнбиотех ХХК, Cheese Republic ХХК, Нүүдэл Жи ХХК, НВЦ ХХК



Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар анх удаа төрийн бус байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Засгийн газар бизнесийн хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн хэлэлцэл, түншлэлийг хөгжүүлэх, уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор МҮХАҮТ-тай харилцан ойлголцлын Санамж бичиг байгууллаа.

Бизнесийн хууль, эрхзүйн орчинг сайжруулах, Төр, хувийн хэвшлийн хэлэлцэл, түншлэлийг хөгжүүлэх, Бизнесийн орчны судалгааны тайлан, мэдээлэл солилцох тухай тусгасан Санамж бичигт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгч Б.Лхагважав нар гарын үсэг зурлаа.

Гадаад хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ

1. Хятадын Олон улсын худалдааг дэмжих хороо, ОХУ-ын ХАҮТ
2. Монгол дахь Хятадын Хөрөнгө Оруулагчдын Зунхуа Нийгэмлэг
3. Тайваны гадаад худалдааны хөгжлийн зөвлөл (TAITRA)
4. Монгол, Өвөр Монголын Бизнесийн Ерөнхий Холбоо /MIMCC/
5. Оросын ТББ «Бизнес Орос»
6. Соех Со., Ltd
7. Тюмени ХАҮТ
8. Хятадын худалдааг дэмжих хороо
9. Монгол-Шанхайн Бизнес Эрхлэгчдийн Хамтын ажиллагааны нийгэмлэг /MSFIC/
10. Чехийн ХАҮТ
11. БНКаЗУ-ын Үндэсний танхим «Атамекен»
12. Казахстаны Гадаад худалдааны танхим
13. Автономит Ашгийн бус байгууллага «Гадаад худалдаа олон улсын эдийн засгийн харилцааны хөгжлийн зөвлөл»
14. Туркийн Гадаад эдийн засгийн харилцааны зөвлөл
15. Тайванийн импорт экспортын нийгэмлэг

Танхимын дарга САССИ дэд ерөнхийлөгчөөр улиран сонгогдсон.

Ази Номхон Далайн Орнуудын Худалдаа Аж үйлдвэрийн Танхимуудын Нэгдсэн Холбооны (САССИ) 32 дахь бага хурал Туркийн Истанбул хотноо болох үеэр САССИ-ын 90 дэх удаагийн Зөвлөлийн хурал болж, уг хурлын шийдвэрээр МҮХАҮТ-ын дарга М.Оюунчимэг, Туркийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимуудын Нэгдсэн Холбооны (ТОВВ) Ерөнхийлөгч М.Рифат Хисаржыклыоглу нарын хамт САССИ-ын дэд Ерөнхийлөгчөөр улиран сонгогдов.



СУДАЛГАА



Бизнес итгэлийн индекс

2017 онд өнөөгийн байдлын бизнес итгэлийн индекс нь -0.32 гэсэн дүнтэй гарсан бөгөөд энэ нь 2012 оноос хойш өмнөх онуудаас хамгийн сайн дүн болж байна. Харин “бизнесийн орчин сайжирна” гэсэн бизнес эрхлэгчдийн хүлээлт сүүлийн 4 жилд дунджаар 37% байсан бол энэ жил 58% болж сүүлийн 5 жилээс 2018 онд бизнест хамгийн эерэг жил байна гэж хүлээж байна.

Өрсөлдөх чадварын судалгаа


МҮХАҮТ-ын 21 аймаг дахь салбар танхим нь эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвтэй хамтран Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааг 2018 явуулсан.

Энэхүү судалгааны хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлэхдээ Эдийн засгийн тамир тэнхээ, Засаглалын үр ашиг, Бизнесийн үр ашиг, Дэд бүтэц гэсэн үндсэн 4 бүлэгт багтах 180 шалгуур үзүүлэлтийг ашигласан.

2018 онд хамгийн их өөрчлөлт гаргасан аймгууд:

Хамгийн их ахиц гарсан аймгууд: Дорноговь, Хэнтий, Говьсүмбэр, Өвөрхангай

Хамгийн их буурсан аймгууд: Булган, Архангай, Хөвсгөл



Хүнд суртлын индекс

“Хүнд суртлын индекс” судалгаагаар төрийн үйлчилгээний цаг хугацаа, зардал, баримт бичгийн тоо зэрэг бодит үзүүлэлтүүдэд тулгуурлан бодитой тооцож гаргах зорилгоор Азийн сангийн дэмжлэгтэйгээр аргачлалыг шинэчлэн боловсруулж явуулсан. Хүнд суртлын индексийн судалгааг Улаанбаатар хот болон орон нутгийн бизнес эрхлэгчдээс ганцаарчилсан ярилцлага авах хэлбэрээр энэ оны 10–11-р сард явуулж нийт 1910 аж ахуйн нэгжийг хамруулан төрийн 54 байгууллагын давхардсан тоогоор 2009 үйлчилгээг үнэлүүлсэн. Хүнд суртлын ерөнхий индекс 2018 онд 2.51 гэж үнэлэгдсэн нь 2015 оны 2.72 гэсэн индексээс буурсан дүнтэй гарсан бөгөөд харин төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртлын дундаж индекс нь 2018 онд 3.29 гэсэн дүнтэй гарсан.



Төрийн өмчит компаниудын засаглалын тойм судалгаа

Энэхүү тойм судалгаагаар төрийн өмчит 45 байгууллагын 2017 оны ашиг орлогын мэдээ, байршил, ТУЗ-ийн гишүүд болон хараат бус гишүүдийн мэдээллийг тус тус гаргасан. Нийт 278 ТУЗ болон хараат бус гишүүн байснаас давхардсан тоогоор дараах байгууллагуудын төлөөлөл төрийн өмчит компаниудын ТУЗ-д орж ажиллаж байгаа бөгөөд байгууллагаар нь харуулбал:

- Эрчим хүчний яамны 5 албан хаагч /1–3 компани/
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 5 албан хаагч /1–2 компани/
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам– 1 албан хаагч /1–2 компани/
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар 2 албан хаагч /1–2 компани/
- Сангийн яамны 2 албан хаагч /1–3 компани/

АРГА ХЭМЖЭЭ

Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ–уудын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Джамал Инайшвилигийн айлчлал

Ази, Номхон Далайн Бүс Нутгийн ХАҮТ–ын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Джамал Инайшвили Монгол улсад 2018.09.05–10–ны хооронд айлчлан ирсэн. Айлчлалын хүрээнд “Ази Номхон Далайн Бүс Нутгийн Худалдаа Аж Үйлдвэрийн

Танхимуудын Холбоогоор дамжуулан бизнесийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь” чуулга уулзалт, Ази Номхон далайн бүс нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан бөгөөд уг чуулгануудад гадны 7 орны 32 төлөөлөгч, дотоодын 500 орчим бизнес эрхлэгчид оролцсон.

Мөн Ерөнхийлөгч Джамал Инайшвили МУ–ын ерөнхийлөгч Х.Баттуга, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нартай уулзалт хийв.



МҮХАҮТ болон ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл Олон улсын худалдааны төвөөс шагнал хүртлээ.

“Олон Улсын Худалдааны Төв”–өөс МҮХАҮТ, ГХАҮТХ хамтран хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй “Хонины ноос болон чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл”–ийг өндрөөр үнэлэн, НҮБ–ын “Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж буй байгууллага”–аар онцолж, шагнал олголоо.



Монгол–Оросын санаачлага–2018

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ–ын Ерөнхийлөгч В.В.Путин нарын 2017 онд хүрсэн тохиролцоо ажил хэрэг болж, “Монгол–Оросын санаачилга–2018” цуврал арга хэмжээ 6 дугаар сарын 7–9–ний өдрүүдэд Улаанбаатар хотод болсон. Энэ үеэр дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

- “Монгол–Орос: Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа стратегийн түншлэлийг хөгжүүлэх түлхүүр хүчин зүйл болох нь” эдийн засгийн чуулга уулзалт
- Оросын дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн болон Оросын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа
- И.Моисеевын нэрэмжит академик чуулгын тоглолт



B2B уулзалт

Бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, тодорхой асуудлын талаарх мэдээллийг хуваалцах, санал солилцох чөлөөт индэрийг бий болгох зорилгоор B2B уулзалтуудыг тодорхой сэдвийн хүрээнд 8 удаа зохион байгуулж тухайн асуудал хариуцсан эрдэмтэн судлаач, мэргэжлийн экспертүүд болон олон улсын бизнес эрхлэгчид гээд нийт давхардсан тоогоор 1224 бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан.

1. Үзэсгэлэн худалдаанд бараа бүтээгдэхүүнээ хэрхэн танилцуулах вэ
2. Барилгын материал ханган нийлүүлэгчдийн уулзалт
3. Худалдаа
4. Бизнесийн эрх зүй
5. Европын холбооны МУ–ын худалдааг дэмжих төсөл
6. Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хэмнэлтийг нэвтрүүлэх
7. Мэргэжлийн боловсрол
8. Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ 2020 нийслэлийн дэд хөтөлбөр

Business breakfast



Бизнес эрхлэгчдийг төртэй холбох, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах зорилгоор “Business breakfast” өглөөний уулзалтыг нийт 5 удаа зохион байгуулсан. Салбарын асуудал эрхэлсэн сайд нар болон эдийн засагч нартай уулзаж санал бодлоо солилцох уг уулзалтанд давхардсан тоогоор 500 орчим бизнес эрхлэгчид оролцож 99 компаниас 148 санал асуулт ирснийг холбогдох яамд руу уламжилсан, ХХААХҮЯ–с 15 компанийн 31 асуултад бичгээр хариу ирүүлснийг холбогдох ААНБ, бизнес эрхлэгчдэд имэйлээр хүргүүлсэн.

1. МУ–ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх
2. Байгаль орчин аялал жуулчлалын сайд Цэрэнбат
3. Нийслэлийн засаг дарга С.Батболд
4. Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан
5. ХХААХҮ–ийн сайд Б.Батзориг

“Төвийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган–2018”

Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны төвөөс санаачлан зохион байгуулж байгаа “Төвийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган–2018” “Өнөөдрийн шийдвэр, ирээдүйн хөгжил” сэдвийн хүрээнд Дархан–Уул аймагт 2018.10.26 амжилттай болсон.

Тус чуулганд МҮХАҮТ–ыг төлөөлөн орлогч дарга М.Сарандаваа болон Дархан–Уул, Төв, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгийн ИТХ–ын дарга, Засаг дарга, аймгийн ИТХ–ын Төлөөлөгчид, Салбар танхимын дарга, бизнес эрхлэгчдийн төлөөллүүд оролцож, өөрсдийн аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтэд тулгуурлан урт хугацаанд бодлогын түвшинд хамтран ажиллах боломж, хөгжлийн төсөл, хөтөлбөрийн уялдааг сайжруулах талаар хэлэлцсэн.



ШАГНАЛ, ШАЛГАРУУЛАЛТ

ТОП-100 аж ахуй нэгж

Монгол Улсын Засгийн Газар, МҮХАҮТ хамтран жил бүр Монгол улсын нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй ТОП-100 аж ахуйн нэгжийг өргөмжилдөг уламжлалтай бөгөөд 17 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан. 2015 оноос эхлэн Сангийн Яам, Татварын Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий Газар, Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн шинэ аргачлалаар 4 дэх жилдээ эрэмбэллээ.



Торгоны зам – 2018



2007 оноос нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй Олон улсын байгууллагууд, хоёр талын техникийн туслалцааны болон бусад гадаадын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүд, Дипломат төлөөлөгчийн газрууд, гадаадын хөрөнгө оруулагчид болон гадны иргэдийг онцлон шалгаруулах, урамшуулан дэмжих, тэднийг нийтэд таниулах зорилгоор “Торгоны зам” шагналыг гардуулдаг уламжлалтай бөгөөд 2018 онд 7 номинациар 13 аж ахуй нэгж, төсөл хөтөлбөр болон хувь хүнийг шалгаруулан шагнал олгосон.

Үндэсний чанарын чуулган–2018

Дэлхийн чанарын өдрийг тохиолдуулан Монгол Улсын Засгийн Газартай хамтран Үндэсний чанарын 7 хоногийн хүрээнд Үндэсний чанарын чуулган арга хэмжээг 4 дэх жилдээ зохион байгуулсан. Шадар сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсэг Үндэсний чанарын шагналын шалгаруулалтыг шилдэг байгууллага, шилдэг үйлчилгээ, шилдэг бүтээгдэхүүн гэсэн номинациудаар явуулсан.



Entrepreneur–2018



МҮХАҮТ–аас жил бүр уламжлал болгон тухайн оны онцлох 10 аж ахуй нэгж салбарын шилдгүүдийг тодруулдаг “Entrepreneur–2018” шагнал гардуулах ёслолын арга хэмжээг 22 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан.

Chamber bus хөтөлбөр

Chamber Bus арга хэмжээг нийт 13 удаа зохион байгуулсан. 9 аймаг, 4 дүүрэг хамрагдсан ба нэг удаа ОХУ-ын Улаан-Үүд хот руу уг арга хэмжээ зохион байгуулагдаж нийт 540 гаруй бизнес эрхлэгчид болон хувь хүмүүс хамрагдлаа.



Entrepreneur challenge хөтөлбөр

Entrepreneur challenge хөтөлбөрийг Баянхонгор, Говь-Алтай, Завхан зэрэг 3 аймагт хэрэгжүүлж орон нутгийн 250 гаруй бизнес эрхлэгчид буюу шинээр бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудыг хамруулан тэдгээрийг чадавхижуулах, бизнес эрхлэхэд суурь мэдлэг, чадвар олгох сургалт, семинарыг зохион байгуулахаас гадна олон улсын экспертүүдийн хамт зөвлөгөө, мэдээлэл өгч амжилттай ажилласан.

Бусад арга хэмжээнээс дурдвал:

1. Монгол экспорт хөтөлбөрийн төслийг танилцуулах уулзалт
2. БНХАУ-ын зах зээлд нэвтрэх боломж сэдэвт сургалт семинар
3. ИТС буюу Олон улсын Худалдааны Төвийн гүйцэтгэх захирал Аранча Гонзалес бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй хийсэн уулзалт
4. ЕХ-ны Худалдааны өдөрлөг
5. Маркетингийн зөвлөгөө өгөх нээлттэй өдөрлөг

БИЗНЕС УУЛЗАЛТУУД

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, зах зээлийг өргөжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Монгол улсад 5 удаагийн бизнес уулзалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 893 хүнийг хамруулсан. Гадаадын 4 оронд 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 430 хүнийг оролцуулав.

Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Япон улсад хийх айлчлалын хүрээнд хийсэн бизнес форум



Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Япон улсад хийсэн айлчлалд 16 бизнес эрхлэгчид аж ахуйн нэгжүүдийн гадаад улсад экспорт хийх, зах зээлээ тэлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ сурталчлах мөн шинэ түнш байгууллагатай болох зорилгоор дагалдан явсан.

2018 оны 12 сарын 12-ны өдөр Монгол Улс, Япон Улс хоорондын Засгийн газар, хувийн хэвшлийн худалдаа, хөрөнгө

оруулалтын 9 дүгээр зөвлөлдөх уулзалтанд хамрагдсан. Монголын ААН-н төлөөллүүд мөн Японы талын Засгийн газар, төрийн ажилтан албан хаагчид болон бизнесийн төлөөлөл нийт 300 гаруй хүн оролцсон.

Монгол Улсын Засгийн газар, ЖЕТРО болон МҮХАҮТ-ын зохион байгуулсан Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн форум болж өнгөрсөн.

Бусад бизнес уулзалтууд:

1. Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНСУ-д хийх айлчлалын хүрээнд зохион байгуулсан Монгол-Солонгосын бизнес уулзалт
2. Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНХАУ-д хийх айлчлалын хүрээнд зохион байгуулсан Монгол-Хятадын бизнес уулзалт
3. Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Япон улсад хийх айлчлалын хүрээнд зохион байгуулсан Монгол-Японы бизнес форум
4. Японы Foodex-2018 арга хэмжээ
5. БНХАУ-д зохион байгуулагдсан Монгол-Орос-Хятадын гурван талт уулзалт
6. Монгол-Тайваны бизнес уулзалт
7. Монгол-Австрийн бизнес уулзалт
8. Silk road International Chamber of Commerce гүйцэтгэх зөвлөлийн хурлын хүрээнд дэх форум
9. Олон улсын хөрөнгө оруулалтын банкны чуулга уулзалт
10. Монгол-Оросын санаачилга арга хэмжээний хүрээнд дэх бизнес форум

ҮЗЭСГЭЛЭН

Дотоод үзэсгэлэн

Үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх зорилгоор 10 орчим үзэсгэлэнг төрийн болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

“Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи-2018”

“Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи-2018” олон улсын үзэсгэлэнг 21 дэх жилдээ зохион байгуулав. Жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, экспортыг дэмжих, дэвшилтэт технологийг танилцуулах зорилгоор зохион байгуулагддаг тус үзэсгэлэнд Монгол улсаас 121, Тайваний 4, Хонконг, Пакистан, Малайз, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 14 жижиг дунд үйлдвэр эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулсан.



“Улаанбаатар түншлэл–2018 олон улсын үзэсгэлэн”

МҮХАҮТ, НЗДТГ–тай хамтран Монгол Улсад үзэсгэлэнгийн салбар үүсч хөгжсөний 43 жилийн ойд зориулан зохион байгуулсан “Улаанбаатар түншлэл–2018” олон улсын намрын үзэсгэлэнд нийт 80 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцсоноос хүнсний салбараас 40, хөнгөн үйлдвэрийн салбарын 50 гаруй аж ахуйн нэгж оролцсон. Энэ удаагийн үзэсгэлэнд ХонКонг, Тайванийн 13 аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгчид оролцсон.



Бусад үзэсгэлэн

1. Цагаан сар–2018
2. Ногоон техник, технологи
3. Монгол–Оросын санаачилга 2018
4. Их хотын хямдрал фестиваль
5. Ворота в Азию–2018

Гадаад үзэсгэлэн




Монголын эскпортын бараа бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахад дэмжих, сурталчлах зорилгоор БНХАУ, БНСУ, ХБНГУ, БНСВУ, Малайз зэрэг нийт 5 улсад 14 олон улсын үзэсгэлэнд давхардсан тоогоор 494 бизнес эрхлэгчид оролцуулав.

1. Гуан–жу хотын Canton Fair–2018
2. Эрээн хотын үзэсгэлэн
3. Тианжин хотын 24 дэх удаагийн олон улсын импортын бараа бүтээгдэхүүний эскпо
4. Манжуур хотын 14 дэх удаагийн олон улсын шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн
5. Хайлаар 2018 Хятад–Орос–Монгол 3–н орны эдийн засаг, худалдааны хэлэлцээрийн үзэсгэлэн
6. Шинжин Уйгарын Өөртөө засах орны Хятад–Ази–Европын эскпо
7. Эрээн хотын Хятад–Монгол–Орос 3 талт чуулга уулзалт, үзэсгэлэн
8. Шандун мужийн Лин–И хотын 9 дэх удаагийн олон улсын худалдаа, логикийн экспо
9. Сөүл хотноо Supremium, Korea food week үзэсгэлэн
10. Герман улсын Базаар Берлин экспо
11. Вьетнам экспо–2018
12. Эрээн хотын 2 дахь удаагийн олон улсын үндэстэн ястны онцлог бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн
13. Малайзын MIHAS Халал бүтээгдэхүүний үзэсгэлэн
14. Гуан–жоу хотын сав баглаа боодлын үзэсгэлэн

СУРГАЛТ

МҮХАҮТ–аас Гишүүд болон бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдлэг, мэдээллээр хангах зорилгоор Гадаад худалдааны академийн сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 3700 орчим хүнийг сургалтанд хамруулсан байна.

1. Гадаад худалдааны менежерийн сургалт
2. Даргын туслах бэлтгэх сургалт
3. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт
4. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан сургалт
5. Богино болон захиалгат сургалт




Танхимын бусад газар хэлтсүүдээс 2018 онд бизнес эрхлэгчдэд зориулсан дараах сэдэвчилсэн сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

1. Байгаль орчинд ээлтэй, техник технологи нэвтрүүлсэн иргэн ААН, байгууллагыг дэмжин урамшуулах журмыг сурталчлах сургалт
2. Бизнес ба авлига сэдэвт сургалт
3. “Дэлхийн худалдааны байгууллага ба Монгол улс” сэдэвт сургалт
4. Эдийн засгийн түншлэлийн хэрэгжилтийн тухай сургалт
5. Японы зах зээлт нэвтрэх тухай сургалт
6. Хятадын зах зээлд нэвтрэх тухай сургалт




ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ


Гарал үүслийн гэрчилгээ




Экспертизийн үйлчилгээ



Бусад худалдааны баримт бичгүүд



Органик бүтээгдэхүүний гэрчилгээ




Бизнесийн хэрэг, маргааны шийдвэрлэх үйлчилгээ

2018 онд шинээр 74 хэрэг хүлээн авсан бөгөөд 66 хэргийг хянан шийдвэрлэсэн. Арбитрын урьдчилсан болон хэрэг шийдвэрлэх 376 хуралдаан зохион байгуулсан. Арбитрын хэрэг маргаанд оролцож байсан эсэх талаарх 280 лавлагаа тодорхойлолт гаргаж үйлчилсэн. Танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвд нийт 7 хүсэлт ирснээс 3 хүсэлтийг нь шийдвэрлэсэн.



Шинэ бүтээл бүтээгдэхүүний загварт эрхийн хамгаалалт, барааны тэмдэгт олгох үйлчилгээ



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР



МҮХАҮТ болон ГХАҮТХ хоорондын хамтын ажиллагааны төсөл

2018 оны 4 дүгээр сард ProValue төслийн I үе шатны үнэлгээ хийж амжилттай хэрэгжсэн гэж дүгнэн төслийн II үе шатыг 2018 оны 9 дүгээр сарын 1 –ээс 2021 оны 8 дугаар сарын 31 хүртэл хэрэгжүүлэхээр болсон.

Төслийн хүрээнд төсөлд хамрагдсан үйлдвэрлэгч нарыг чадавхижуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулсны дотор олон улсын экспертүүдийг урьж Увс аймагт “Чацарганы бүтээгдэхүүн хөгжүүлэлт”, Архангай аймагт “Эсгий бүтээгдэхүүний загварыг сайжруулах” сургалтыг зохион байгуулсан. Мөн Увс аймгийн чацарганын кластер багийнханыг ХБНГУ–д туршлага судлах аялалд хамруулсан.



Монголын Худалдааг Дэмжих Төсөл

Монголын худалдааг дэмжих төслийг хэрэгжүүлэх хүрээнд 2018 онд “ЕХ–ны худалдааны өдрүүд” арга хэмжээг 250 бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан.

Монгол улсын экспортын орчны болон экспортын чиглэлийн кластер хөгжүүлэх судалгааг олон улсын болон үндэсний судлаачдын баг бүрдүүлэн хийсэн. Судалгааны хүрээнд нийт 10 орчим салбарын 100 гаруй экспортлогчидтой салбарчилсан уулзалтууд хийж экспортын чиглэлийн ноос, гоо сайхан, чацарганы тос, арьс шир 4 салбарыг сонгон кластер байгуулах ажлыг эхлүүлсэн.

Бизнес эрхлэгчдийг мэдээллээр хангах үүднээс ТРАМ төслийн санхүүжилтээр “Экспортын замын зураглал”, “АТА карнет системийн гарын авлага”, “ЕХ–ны ХЕС–ийн танилцуулга”, “Төсөл боловсруулах гарын авлага”, “Бизнес саналууд” зэрэг гарын авлагуудыг боловсруулан хэвлүүлэв.

Худалдаа Хөнгөвчлөх Хорооны гишүүн байгууллагуудын төлөөлөл бүхий багийг Гүрж улсын төрийн байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээний туршлагатай танилцуулан, Гүржийн ХАҮТ–тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.



Нийслэлийн засаг даргын тамгын газар болон Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв төслийн хүрээнд 32 удаагийн сургалт, 5 удаагийн арга хэмжээ, 8 чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж нийт 1014 хүнийг хамруулсан байна.

Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр Азийн сангийн хэрэгжүүлж буй Ардчилсан оролцотойгоор Төрийн Албанд Сайн Засаглал, Ил тод Байдлыг Бэхжүүлэх нь төслийн (STEPS) хүрээнд МҮХАҮТ нь бизнес эрхлэгчдийн авлигын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийг Авлигатай тэмцэх газартай хамтран боловсруулж уг хөтөлбөрөөр 19 компанийн 520 бизнес эрхлэгч, ажилтнуудад сургалт явуулсан.



“Нийгмийн түншлэл” төсөл

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)–тэй хамтран “Нийгмийн түншлэл” төслийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- “ХБНГУ–ын хос систем дэх үйлдвэрийн дадлагын чанарыг хангах нь” зөвлөмж
- МҮХАҮТ–ын гишүүн байгууллагын 150 хүнээс “Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш ажиллаж буй өнөөгийн нөхцөл байдлын талаарх судалгаа” авч, хэлэлцүүлэг зохион байгуулав.
- Үйлдвэрлэлийн дадлага сургалтын чиглэлээр 3 төрлийн зурагт хуудас, 3 төрлийн шторк, 2 төрлийн богино хэмжээний кино зэрэг сурталчилгааны материалыг боловсруулав.



- ААНБ болон МБСБ–ын хоорондын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээллийн бааз бий болгох зорилгоор МҮХАҮТ–ын дэргэд Нэг цэгийн үйлчилгээг байгуулан ажиллаж байна.





“Монголд үр дүнтэй, бизнес гишүүнчлэлтэй холбоодыг хөгжүүлэх төсөл”

ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр Зөвлөх үйлчилгээний «Монголд үр дүнтэй, бизнес гишүүнчлэлтэй холбоодыг хөгжүүлэх төсөл»-д Сүхбаатар, Говь-Алтай, Хэнтий аймгууд дахь салбар танхимууд хамрагдаж гишүүд бизнес эрхлэгчдэд хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор байгууллагын стратеги, маркетингийн болон бизнесийн төлөвлөгөө боловсруулсан бөгөөд ажилтнуудыг чадавхижуулах чиглэлээр төрөл бүрийн сургалтуудад хамрагдсан.



НҮБ-ын Даян дэлхийн гэрээний Монгол дахь сүлжээний удирдах зөвлөлийг 4 компанитай байгуулж 3 компани албан ёсны гишүүнээр элссэн.

НҮБ-ын Даян дэлхийн гэрээний төв байгууллагатай хамтран Монгол дахь сүлжээний үйл ажиллагааны чанарын стандартын үнэлгээ хийлгэв.



Менежментийн зөвлөх үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч McKinsey & Company хамтран Монголын компаниудын үйл ажиллагаанд байгууллагын хөгжлийн индекс (ОНИ) үнэлгээг хийлгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг хөтөлбөрт нийт 5 компанийг төлбөрийн 50%-ийн хөнгөлөлтэй нөхцөлөөр хамруулахаар болсон.



Орон нутгийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 2009 онд Органик Монгол хөтөлбөрийг дараах компаниудын санхүүжилтээр байгуулсан.

Эх үүсвэр /сая төг/

МҮХАҮТ	20.0
Хасбанк	200.0
Капитал банк	100.0
Бишрэлт холдинг ХХК	100.0
Петровис ХХК	100.0
Макс импекс	20000\$
Энержи ресурс ХХК	20.0
НЗБСан	15.0

2018 онд Дархан, Сэлэнгэ, Төв аймгуудад төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 18 төсөл шалгаруулсан.


ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ISO9001 чанарын олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

МҮХАҮТ Дэлхийн 140 гаруй оронд 840 салбар, 320 гаруй лабораторитай, хяналт, шалгалт, үнэлгээний дэлхийд тэргүүлэгч байгууллага Швейцарийн Женевт төвтэй “SGS” компаниар аудит хийлгэж ISO 9001:2015 шаардлагыг хангаж, баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан.

МҮХАҮТ-ын чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээ нь:

Бизнесийг дэмжих ба бодлогын өмгөөллийн үйлчилгээ, үүнд бизнес арга хэмжээ, судалгаа, үзэсгэлэн, сургалт, гадаад худалдааны баримт бичгүүд ба ногоон шошго олгох, бизнесийн маргааны эвлэрүүлэн зуучлал ба арбитрийн шүүх






МҮХАҮТ Олон улсын худалдааны төвөөр Benchmarking буюу харьцуулсан үнэлгээг дахин хийлгэлээ.

2016 онд Олон улсын худалдааны төв (ITC)-өөс МҮХАҮТ-ын үйл ажиллагаан дээр Бэнчмаркинг буюу харьцуулсан үнэлгээг хийсэн. Тус үнэлгээ нь нийт 225 шалгуур үзүүлэлтээр Манлайлал болон чиглэл, Үр дүн болон хэмжилт, Нөөц болон үйл явц, Бүтээгдэхүүн үйлчилгээний хүргэлт гэсэн 4 үндсэн гол үзүүлэлтэнд оноо өгдөг үнэлгээ бөгөөд МҮХАҮТ нь 46,43% буюу дэлхийн бусад танхимуудтай харьцуулахад дундаж зэрэглэлд үнэлэгдсэн.


Уг үнэлгээг хийх хугацаанд ОУХТ-ийн экспертүүд МҮХАҮТ-ын давуу болон сул талуудыг тодорхойлсон ба үр дүн дээр нь үндэслэн үндсэн 4 зорилт бүхий Танхимын гүйцэтгэлийг сайжруулах замын зураг (PIRM) төслийг 2017–2018 оны хугацаанд хэрэгжүүлсэн.

Төслийн үр дүнд МҮХАҮТ дээр 2018 оны 11-р сард дахин хийгдсэн бөгөөд Харьцуулсан үнэлгээгээр 57,84% гэсэн үнэлгээг авсан.



Мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн систем

2015 оноос эхлэн үйл ажиллагаагаа түргэн шуурхай болгох, шийдвэр гаргалтыг хурдасгах, гишүүдэд чиглэсэн стратегийг дэвшилтэт технологи ашиглан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн сан дээр үндэслэн дүн шинжилгээ, анализ хийх, гишүүн болон үйлчлүүлэгчдийн талаарх бүх мэдээллийг төвлөрүүлэх, гишүүдээс ирсэн санал гомдлыг үйл ажиллагаандаа бодитоор тусгах, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх зорилгоор “Мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн систем”-ийг үе шаттайгаар нэвтрүүлж 25 модуль, 211 хэсэгтэйгээр хөгжүүлэн 2018 онд бүрэн ажиллагаанд оруулсан.



МҮХАҮТ–ЫН ДЭРГЭДЭХ БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛИЙН ЖАГСААЛТ

1. Аялал жуулчлалын зөвлөл
2. Импортлогчдийн зөвлөл
3. Итгэмжлэгдсэн лабораторуудын зөвлөл
4. Ноос ноолуурын зөвлөл
5. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөл
6. Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл
7. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл
8. Эдийн засгийн бодлогын зөвлөл
9. Сэргээгдэх эрчим хүчний зөвлөл /нэр өөрчлөх/
10. Хууль зүйн бодлогын зөвлөл
11. Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зөвлөл
12. Инноваци ба Гарааны бизнесийг дэмжих зөвлөл
13. ОХУ–тай хамтран ажиллах зөвлөл
14. Хятад улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
15. Чөлөөт бүсийн хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл
16. Экспортыг дэмжих зөвлөл
17. Япон улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
18. Монгол Австрийн хамтын ажиллагааны зөвлөл
19. Худалдааг хөнгөвчлөх, тээвэр, ложистикийн зөвлөл
20. Франчайзингийн зөвлөл

МҮХАҮТ–ААС ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦДОГ ХОРОО, ЗӨВЛӨЛ АЖЛЫН ХЭСГИЙН ЖАГСААЛТ

№	Харьцдаг байгууллагууд	Зөвлөл, хороо	Ажлын хэсэг
1	Засгийн газар	Эдийн засгийн бодлогын зөвлөлийн гишүүн	
2		Тогтвортой хөгжлийн үндэсний хороо	
3		Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүн	
4	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн гишүүн	
5		Монгол улсын Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөл	
6	Гадаад Харилцааны Яам	“Монголын мянганы сорилтын сан”-гийн удирдах зөвлөлийн гишүүн	
7	Сангийн яам	Гаалийн тарифын зөвлөл	
8	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн удирдах хорооны гишүүн	
9		Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үндэсний Зөвлөлийн гишүүн	
10	Монголбанк	Хяналтын зөвлөлийн гишүүн	
11	Компанийн засаглалын үндэсний зөвлөл	Гишүүн	
12	Дэлхийн танхимуудын холбоо	Ерөнхий Зөвлөлийн гишүүн	
13	Ази номхон далайн танхимуудын холбоо	Дэд ерөнхийлөгч	
14	Торгоны замын Олон улсын худалдааны танхим	Дэд дарга	
15	Засгийн газар		Үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг удирдан зохион байгуулах үүрэг төв комиссын гишүүн
16	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэдэх Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны дэд дарга	
17			“Эдийн засгийн чуулган” арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн
18	Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо		Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг бэлтгэх ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийн гишүүн
19	Гадаад Харилцааны Яам	Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөл	
20			Монгол улс Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсгийн гишүүн

21	Үндэсний хөгжлийн газар		Баялаг бүтээгчдийг дэмжих багц бодлого, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн
22	Үндэсний статистикийн хороо	Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүн	
23		Хилийн боомтын үндэсний зөвлөлийн гишүүн	
24	Сангийн яам		Монгол улсын татварын орчинд дүн шинжилгээ хийж, татварын тэгш, шударга байдлыг дээшлүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, татварын орлогод нөлөөлөх, эсхүл орлого нэмэгдүүлэх зөвлөмж боловсруулах ажлын хэсэг
25	Стандарт, хэмжил зүйн газар	Цахилгаан техникийн үндэсний хорооны гишүүн	
26	Азийн сан	Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх төсөл	
27	Монгол улсын засгийн газар	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэгтэй зөвлөл	
28	Монгол Улсын Их Хурлын байнгын хороо		Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн дэд ажлын хэсэг
29	Си Жи Эф ХХК	УЗ-ийн гишүүн	
30	Стандарт, Хэмжил Зүйн Газар	Стандартчиллын үндэсний зөвлөл	
31	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		Монгол-Японы засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан худалдаа, хөрөнгө оруулалтын 8 дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах ажлын хэсэг
32	Гадаад харилцааны яам		“Монгол-Хятадын Экспо” арга хэмжээг 2 жил тутам зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг
33	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга төслийн удирдах хорооны гишүүн	
34	Эдийн засгийн байнгын хороо		Банкны тухай хуулийг УИХ-д өргөн мэдүүлэх ажлын хэсэг
35	Санхүү эдийн засгийн их сургууль	Эрдмийн зөвлөл	
36	Монгол улсын Засгийн газар		Замын үүд, Эрээний боомтыг түшиглэн хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн
37	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн	

38	Гадаад Харилцааны Яам	Монгол Оросын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан технологийн засгийн газар хоорондын комисс	
39		Монгол Оросын хил худалдаа бүс нутгийн хамтын ажиллагааны дэд комиссын ажлын хэсгийн гишүүн	
40		Монгол – Польш худалдаа эдийн засгийн комисс	
41		Монгол – Латви худалдаа эдийн засгийн комисс	
42		Монгол– Киргиз худалдаа эдийн засгийн комисс	
43		Монгол–Казакстан худалдаа эдийн засгийн комисс	
44		Монгол Чех худалдаа эдийн засгийн комисс	
45		Монгол–Оросын найрамдлын нийгэмлэг	Тэргүүн
46	Нийслэлийн засаг даргын тамгын газар		Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ –2020 хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүн
47	Засгийн газрын хэрэг эрхлэх газар		Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
48	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам		Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
49			Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг
50	Зээлийн Батлан Даалтын Сан	Удирдах зөвлөлийн гишүүн	
51	Стандарт Хэмжил Зүйн Газар	Чанарын удирдлагын техникийн хорооны гишүүн	
52		Техникийн хяналтын байгууллагын итгэмжлэлийн техникийн дэд хорооны гишүүн	
53	Хөгжлийн банк	ТУЗ–ын Хараат бус гишүүн	
54	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөл	
55	Үндэсний хөгжлийн газар		Монгол улсын үндэсний сайн дурын илтгэлийг бэлтгэх ажлын хэсэг / Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр/
56	Гадаад харилцааны яам		Монгол улс, БНСУ хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, нөхцлийг судлан, санал, дүгнэлт гаргах судалгааны баг
57	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар		Хүүхэд хамгааллын бодлого боловсруулах ажлын хэсэг
58			Хүүхдийн эрх болон тэдний сайн сайханд бизнес хэрхэн нөлөөлж, мөн ямар арга хэмжээ авч буйг нэгтгэн харах, улмаар холбогдох хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах зорилготой судалгааны ажлын хэсгийн гишүүн

59	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээний дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах комисс	
60	Эрчим хүчний яам		Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг
61			Эрчим хүч хэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг
62	Стандарт, хэмжил зүйн газар	Хэмжилзүйн зөвлөл	
63	Зээлийн Батлан Даалтын Сан	Хяналтын зөвлөлийн дарга	
64	Монгол дахь австралийн тэтгэлэгт хөтөлбөрүүд	Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулах хорооны гишүүн	
65	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
66			“Жижиг дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг
67			Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсэг
68	Сангийн яам		“Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээл” төслийн удирдах хорооны гишүүн
69			Санхүүгийн түрээс /лизинг/-ийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл бэлтгэх, судалгаа шинжилгээ хийх зорилго бүхий ажлын хэсгийн гишүүн
70	Нийслэлийн засаг даргын тамгын газар		“Улаанбаатарт үйлдвэрлэв” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
71			“Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
72	Цагдаагийн ерөнхий газар	Тендерийн үнэлгээний хорооны гишүүн	
73	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Тендерийн үнэлгээний хорооны гишүүн	
74	Хууль зүй, дотоод хэргийн яам		Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг
75	Гадаад Харилцааны Яам		ГХЯ-ны Дэлхийн Монголчууд ажлын хэсэгт орж ажиллах
76	Гадаад Харилцааны Яам		Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөрийн ажлын хэсэг
77	Сангийн яам		Экспортыг дэмжих төслийн ажлын хэсэг
78	Үндэсний хөгжлийн газар	Монгол улсад төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах тухай орон тооны бус зөвлөл	
79	Хүнс хөдөө аж ахуйн яам		ЗГ-ын Худалдааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн

80	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар		Үндэсний Цахим нэг цонхны бизнесийн процессын ажлын хэсэг
81	Гаалийн Ерөнхий Газар		Гаалийн Ерөнхий газар дээр Гаалийн тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн гишүүн
82	Стандарт Хэмжил Зүйн Газар		“Худалдааны газар, түүний үйлчилгээ” стандартыг шинэчлэх ажлын хэсэг
83	Зам, тээврийн хөгжлийн яам		Үндэсний тээвэр логикийн сүлжээ байгуулах чиглэлээр судалгаа хийж, зураглал гарган ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг
84	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	Орон тооны бус гишүүн	
85			Оюуны өмчийн багц хуулиудын шинэчлэлийн ажлын хэсэг
86	Ашигт малтмал газрын тосны газар		Шингэрүүлсэн шатдаг хийн хангамжийн норм, дүрэм, стандартын ажлын хэсэг
87	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		Газрын тосны бүтээгдэхүүний хуулийн дэд ажлын хэсэг
88	УУХҮЯ, АМГТГ, СХЗГ, ГЕГ Төв лаборатори, ИНЕГ Оншилгоо хэмжил зүйн лаборатори, ОБЕГ, ЗХНЛаборатори, Химийн хүрээлэн, ШУТИС, Хувийн хэвшлээс МТ, Шунхлай, Мойл, Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг, Нефть Хийн Үндэсний ассоциаци		Газрын тосны бүтээгдэхүүний хэвийн хорогдлыг шинэчлэн тогтоох ажлын хэсгийн нарийн бичгийн дарга
89	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар		Өрсөлдөөний тухай хуулийн ажлын хэсэг
90	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дэргэдэх Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны гишүүн	
91			Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хэсэг
92			Дампуурлын хуулийн төслийн ажлын хэсэг
93	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам	Ази, Номхон далайн орнууд дахь уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг даван туулах эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх төслийн удирдах хорооны гишүүн	
94			Мэргэжлийн боловсролын сургалтын бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг
95	Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар		Монгол улсын Засгийн газарт тэтгэврийн шинэчлэлийн талаар чиглэл өгөх, санал боловсруулах ажлын хэсгийн гишүүн



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим,
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17011, UB Post – 101011001

Утас: +976-11-310619

Факс: +976-11-324620

e-mail: policy@mongolchamber.mn

www.mongolchamber.mn